

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

**Бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээнд шаардагдах микробиологийн аргаар тэмцэх ажилд шаардагдах микробиологийн бэлдмэлийн техникийн тодорхойлолтын шаардлагын талаар:**

1. Монгол улсад ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох биобэлдмэлүүдийн жагсаалтын "биородентицид"-ийн хэсэгт орсон ургамал хамгааллын бодис байна.
2. Тендерт оролцогч нь дараах баримт бичгийг бүрдүүлэн ирүүлнэ. Үүнд:
  - 2.1. Санал болгож буй биородентицид /микробиологийн бэлдмэл/-ийн үйлдвэрлэгчийн тухай танилцуулгыг ирүүлнэ.
  - 2.2. Санал болгож буй биородентицидийн танилцуулга.  
(Танилцуулганд бэлдмэлийн худалдааны нэр, хэлбэр, хүчинтэй байх хугацаа, үйлчлэх бодисын нэр, эзлэх хувь, томьёо, үхлийн тун /LD<sub>50</sub>/, өнгө, байгаль дээр задрах хугацаа, нэг га-д зарцуулах хэмжээ, савлалт, хадгалалт, тээвэрлэлт, тухайн бодис, түүний хольц, хаягдлыг устгах аргачлал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд хэрхэн нөлөөлөх талаар, мал, амьтан хордохоос урьдчилан сэргийлэх, хордсон тохиолдолд мөрдөх аюулгүй ажиллагааны талаар орсон байх шаардлагатай). Энэ нь үйлдвэрлэгчээс хэвлүүлж гаргасан заавар, танилцуулга, каталог хэлбэрээр байна.
  - 2.3. Микробиологийн бэлдмэлийн гарал үүслийг тодорхойлох үйлдвэрлэгчийн гэрчилгээ, түүнтэй адилтгах баримт бичиг.
  - 2.4. Эрх бүхий байгууллагаас олгосон тухайн микробиологийн бэлдмэлийг үйлдвэрлэх эрхийн бичиг, түүнтэй адилтгах баримт бичиг.
  - 2.5. Нийлүүлэхээр санал болгож буй микробиологийн бэлдмэлийн талаарх тухайн орны стандарт, чанарын гэрчилгээ, түүнтэй адилтгах баримт бичиг.
  - 2.6. Тухайн микробиологийн бэлдмэлийн дотоодын эсвэл олон улсын бүртгэлийн дугаар.
3. Нийлүүлэх барааны техникийн тодорхойлолтын холбогдох үзүүлэлтийг үнэн болохыг гэрчилсэн баримт бичгийг монгол хэл дээр орчуулан, орчуулгын товчоогоор баталгаажуулан ирүүлнэ.
4. Нийлүүлэгч нь ургамал хамгаалах бодис импортлох, борлуулах тусгай зөвшөөрөлтэй байна.



## Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

**Нэр:** Бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээнд шаардагдах микробиологийн бэлдмэл нийлүүлэх.

**Хэмжээ:** 225 тонн /хоёр зуун хорин тав/-оос багагүй

**Төсөвт өртөг:** 1,320,000,000.00 /Нэг тэрбум гурван зуун хорин сая/ төгрөг

№	<i>Захиалагчийн техникийн тодорхойлолт</i>	<i>Санал болгож буй техникийн тодорхойлолт</i>
1	<p style="text-align: center;"><b>Биородентицидийн ерөнхий үзүүлэлтүүд</b></p> <p>1.1 Биородентицидийн нэр: "Микробиологийн бэлдмэл" эсхүл түүнтэй дүйцэх</p> <p>1.2 Үйлдвэрлэгчийн нэр хаяг:</p> <p>1.3 Нийлүүлэх микробиологийн бэлдмэл нь олон улсын болон Монгол Улсын холбогдох стандарт шаардлага хангасан байна.</p> <p>1.4 Хорон чанар /бэлдмэлээс малд идүүлэхэд 14 хоногт өвчлөхгүй байх/</p> <p>1.5 Родентицидийн хэлбэр нь: өгөөш байна.</p> <p>1.6 Үйлдвэрлэсэн огноо: 2024 онд үйлдвэрлэсэн байна.</p> <p>1.7 Олон улсын бүртгэлийн дугаар:</p> <p>1.8 Идэвхээ хадгалах хугацаа: Холбогдох олон улсын болон үндэсний стандартад заасан хугацаанд тохирсон байна.</p> <p>1.9 Нийлүүлэхээр санал болгож буй тухайн бэлдмэлд олон улсын болон дотоодын итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлт гаргуулсан байна.</p>	
2	<p style="text-align: center;"><b>Биородентицидийн физик, химийн шинж</b></p> <p>2.1 Үйлчлэх бодисын нэр, эзлэх хувь:</p> <p>2.2 Биородентицидийн томьёо:</p> <p>2.3 Үхлийн тун /LD<sub>50</sub>/:</p> <p>2.4 Гадаад байдал: өнгө, үнэр гэх мэт:</p>	
3	<p style="text-align: center;"><b>Биородентицидийн үйлчилгээний механизм</b></p> <p>3.1 Үлийн цагаан оготны аль эд эрхтэнд үйлчилдэг талаар:</p> <p>3.3 Хэрэглэсний дараах үхлийн үр дүн:</p> <p>3.4 Хэрэглэсний дараа байгаль дээр задрах хугацаа:</p>	
4	<p style="text-align: center;"><b>Биородентицидийн савлалт, хадгалалт, хэрэглээ</b></p> <p>4.1 Савлагаа: 20-35 кг-аас илүүгүй хэмжээтэй байна. Хадгалах, тээвэрлэхэд цоорохгүй, бат бэх савлагаатай байна.</p>	
5	<p style="text-align: center;"><b>Биородентицидийн үнэ</b></p> <p>5.1 Нэгжийн үнэ: /кг/төг/</p>	

**Жич:** Нийлүүлэгчийн санал болгож буй бодисын техникийн тодорхойлолтын үзүүлэлт бүрийг үнэн зөв гэдгийг нотлох зорилгоор үйлдвэрлэгчийн хэвлэж гаргасан каталог, танилцуулга, зураг, туршилт, шинжилгээ, судалгааны дүн гэх мэтийг хавсаргаж ирүүлсэн байна.

### Шалгалт, туршилт

1. Санал болгож буй микробиологийн бэлдмэлийг Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораторит шинжлүүлэн хариу бичгийг хавсаргаж ирүүлнэ.

